



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 57249

Улаанбаатар хот

Б.Сайхантуяад сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.9, 37.1.13, 37.1.18, 39 дүгээр зүйлийн 39.1.18, 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалт, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/1306 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам”-ын 4 дүгээр зүйл, 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Бат-Очирын Сайхантуяа нь холбогдох хууль тогтоомж зөрчиж хүний хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтэрч мэдээлэл цуглуулсан нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 1628 дугаар “Дүгнэлт”, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг улсын ахлах бүртгэгч Б.Сайхантуяад үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142401214